

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Аудитор С.Шийлэгмаа
Утас: 261740 Цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.4.2 Авлага, урьдчилгаа	11
3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө	12
3.4.5 Үндсэн хөрөнгө	13
3.4.6 Өр төлбөр	13
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.6 Завсрын аудитын үр дүн	17
4.7 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СНАГ	Санхүү, нийцлийн аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 785
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн харьяатын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд 1,597.6 сая төгрөгийн нэмэлт хөгжүүлэлт хийж, нийт 1035 удаагийн засвар, шинэчлэлтийг хэрэгжүүлэн системийн үйл ажиллагааг сайжруулж, виз, визийн зөвшөөрөл мэдүүлэх үед Монгол Улсад байрлах хаягийг баталгаажуулах болон байршуулж буй иргэн, хуулийн этгээдээс баримт бичиг авах шинэ боломжийг нэвтрүүлсэн байна. Тайлант онд тус системээр дамжуулан визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл болон холбогдох бусад үйлчилгээний нийт 156595 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Тайлант онд K1-10, A3-10 хоногийн визийн хүсэлтийг системээр хүлээн авах хөгжүүлэлтийг хийж, туршилтын шатанд хэрэгжиж байна. Системийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хоёр шатлалт нэвтрэлт (2FA) болон төхөөрөмж бүртгэх тохиргоо 138 албан хаагч ашиглаж эхэлсэн.

МОН-3936 төслийн хүрээнд нийлүүлсэн 5 серверийг Үндэсний дата төвд байршуулж, системийн давхар ажиллагааг хангах бэлтгэлийг хийж байна. Эдгээр хөгжүүлэлтийг нэвтрүүлснээр системийг бүрэн ашиглах нөхцөл бүрдсэн байна.

Z.Yawsar_Fichig20260325 SAG-1 Docx

1526090240

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг киоск машинаас хэвлэн авах боломжийг нэвтрүүлж, 48.8 сая төгрөгийн хөгжүүлэлт хийж, тус үйлчилгээг Чингэлтэй дүүргийн Засгийн газрын XI байр дахь Хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвд байршуулсан киоск машинаар үзүүлж эхэлсэн.

Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суух зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтээ цахим системээр гаргахдаа “Оршин суух үнэмлэх хэвлэх киоск машин” сонголтыг хийж, зөвшөөрөгдсөний дараа баталгаажуулалтыг регистрийн дугаар болон ДАН системд бүртгэлтэй утсанд ирэх нэг удаагийн кодоор хийж, оршин суух үнэмлэхийг 2–5 минутын дотор газар дээр нь хэвлэн авах нөхцөл бүрдсэн байна.

Бусад асуудал

Гадаадын иргэн, харьяатын газар 15.0 сая төгрөгөөр хиймэл оюунд суурилсан чатботыг зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд нэвтрүүлж, цахим үйлчилгээний нэгдсэн систем (isf.mn), байгууллагын цахим сайт болон цахим хуудсанд холбосон байна.

Тус чатбот нь виз, зөвшөөрөл, зөрчил шалган шийдвэрлэлт, иргэний харьяалал зэрэг үйлчилгээтэй холбоотой мэдээллийг Монгол, Англи, Хятад, Солонгос, Орос хэлээр 24 цагийн турш шуурхай хүргэх боломжтой болж, иргэд биечлэн ирэх, утсаар холбогдох шаардлагагүй хаанаас ч компьютер, гар утсаараа зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөл бүрдсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,331,881.7	3,441,253.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	68,126.24	193,143.01
33	АВЛАГА	1,192.87	2,010,442.64
34	УРЬДЧИЛГАА	40,116.46	8,990.97
35	БАРАА МАТЕРИАЛ	1,485,385.92	1,228,677.01
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,737,060.2	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,878,389.13	14,237,649.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,878,389.13	14,237,649.94
39200	Биет хөрөнгө	8,595,267.13	11,721,823.15
39300	Биет бус хөрөнгө	1,283,122	2,515,826.79
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,210,270.84	17,678,903.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,579.43	195,726.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,579.43	195,726.06
41300	Өглөг	23,514.15	30,854.79
41400	Урьдчилж орсон орлого	20,065.28	164,871.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,166,691.4	17,483,177.51
51	Засгийн газрын хувь оролцоо	14,166,691.4	17,483,177.51
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,455,792.52	1,455,792.52
51200	Хуримтлагдсан үр дүн	10,499,039.47	13,815,525.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,211,859.41	2,211,859.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,210,270.84	17,678,903.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	22,473,629.16	25,991,760.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,976,346.18	25,991,760.76
120	Нийтлэг татварын бус орлого	0	17,116,335.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,497,282.99	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	21,590,751.37	22,561,314.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,590,751.37	22,561,314.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,898,645.08	19,501,232.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,827,253.58	12,164,911.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,207,352.92	1,489,096.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	387,540.77	430,519.97
2104	Хангамж, бараа материалын зардал	456,063.88	447,472.88
2105	Нормативт зардал	1,177.5	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	321,688.9	99,988.74
2107	Томилолт, зочны зардал	95,812.97	81,874.09
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,032,174.21	2,963,291.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,569,580.36	1,824,076.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,692,106.29	3,060,082.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	882,877.79	3,430,446.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	454,501.49	113,960.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-454,501.49	-113,960.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	428,376.3	3,316,486.11

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	28,489,967.46	26,745,836.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,270,543.8	5,279,346.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	8,270,543.8	5,279,346.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,270,543.8	5,279,346.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,722,140.67	21,466,489.2
120	Нийтлэг татварын бус орлого	2,722,140.67	4,361,651.12
121	Тусламжийн орлого		17,104,838.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,497,282.99	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,800,391.9	26,454,498.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,800,391.9	26,454,498.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,851,877.54	16,255,715.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,828,256.09	12,164,027.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,207,352.92	1,489,096.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	420,795.43	392,864.51
2104	Хангамж, бараа материалын зардал	455,873.83	331,524.78
2105	Норматив зардал	6,348.4	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	329,097.25	100,179.49
2107	Томилолт, зочны зардал	95,812.97	81,874.09
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,355,147.45	1,630,257.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,193.19	65,890.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,948,514.36	10,198,783.64
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	689,575.56	291,337.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	678,172.44	160,095.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	678,172.44	160,095.46
2200	Дотоод эх үүсвэрээр	678,172.44	160,095.46
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-678,172.44	-160,095.46
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	12,111.7	6,225.17
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-12,111.7	-6,225.17
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-708.58	125,016.77
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,834.82	68,126.24
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,126.24	193,143.01

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,838,279.06	13,838,279.06
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-122,463.96	-122,463.96
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,715,815.1	13,715,815.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	22,500	22,500
9	Тайлант үеийн үр дүн	428,376.3	428,376.3
11	2024 оны 21-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,166,691.4	14,166,691.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	14,166,691.4	14,166,691.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	14,166,691.4	14,166,691.4
19	Тайлант үеийн үр дүн	3,316,486.11	3,316,486.11
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,483,177.51	17,483,177.51

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,844,170.00	16,343,392.19	2,500,777.81	86.7
УРСГАЛ ЗАРДАЛ	18,844,170.00	16,343,392.19	2,500,777.81	86.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,844,170.00	16,343,392.19	2,500,777.81	86.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,178,640.10	12,063,836.43	1,114,803.67	91.5
Үндсэн цалин	5,553,146.50	5,403,889.71	149,256.79	97.3
Нэмэгдэл	4,339,421.00	3,833,943.92	505,477.08	88.4
Унаа хоолны хөнгөлөлт	2,312,271.00	2,133,144.34	179,126.66	92.3
Урамшуулал	973,801.60	692,858.46	280,943.14	71.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,826,753.90	1,474,640.40	352,113.50	80.7
Тэтгэврийн даатгал	1,242,192.60	1,007,432.32	234,760.28	81.1
Тэтгэмжийн даатгал	146,140.60	119,569.09	26,571.51	81.8
ҮОМШӨ-ний даатгал	73,070.00	59,578.33	13,491.67	81.5
Ажилгүйдлийн даатгал	73,070.00	57,777.56	15,292.44	79.1
Эрүүл мэндийн даатгал	292,280.70	230,283.09	61,997.61	78.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	563,906.50	392,864.51	171,041.99	69.7
Гэрэл, цахилгаан	162,457.90	94,814.86	67,643.04	58.4
Түлш, халаалт	178,708.70	149,286.45	29,422.25	83.5
Цэвэр, бохир ус	44,825.10	23,125.50	21,699.60	51.6
Байрны түрээс	177,914.80	125,637.70	52,277.10	70.6
Хангамж, бараа материалын зардал	410,577.50	320,524.78	90,052.72	78.1
Бичиг хэрэг	55,295.60	42,028.91	13,266.70	76.0
Тээвэр, шатахуун	203,541.20	192,340.80	11,200.40	94.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	66,130.30	28,697.86	37,432.44	43.4
Ном, хэвлэл	7,325.50	1,232.00	6,093.50	16.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	78,284.90	56,225.21	22,059.69	71.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	410,577.50	320,524.78	90,052.72	78.1
Норматив зардал	222,636.90	0.00	222,636.90	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	222,636.90	0.00	222,636.90	-
Эд хогшил, урсгал засварын зардал	201,978.90	179,954.79	22,024.11	89.1
Багаж, техник, хэрэгсэл	79,777.30	79,775.30	2.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,797.90	4,942.90	19,855.00	19.9
Урсгал засвар	97,403.70	95,236.59	2,167.11	97.8
Томиллолт, зочны зардал	61,119.30	58,788.04	2,331.26	96.2
Гадаад албан томиллолт	31,709.70	31,323.66	386.04	98.8
Дотоод албан томиллолт	15,110.80	13,310.80	1,800.00	88.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	14,298.80	14,153.58	145.22	99.0

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,855,125.10	1,607,558.03	247,567.07	86.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	857,898.10	818,631.98	39,266.12	95.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,103.80	0.00	1,103.80	-
Даатгалын үйлчилгээ	127,140.70	91,902.67	35,238.03	72.3
Тээврийн хэрэгслийн татвар	10,228.80	6,698.81	3,529.99	65.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,608.40	734.00	874.40	45.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,630.00	178,322.66	32,307.34	84.7
Газрын төлбөр	10,113.90	8,164.61	1,949.30	80.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	636,401.40	503,103.30	133,298.10	79.1
Бараа үйлчилгээний бусад зардал	92,037.00	42,419.54	49,617.46	46.1
Бараа үйлчилгээний бусад зардал	66,226.10	32,874.54	33,351.56	49.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,810.90	9,545.00	16,265.90	37.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	431,394.80	202,805.67	228,589.13	47.0
Бусад урсгал шилжүүлэг	431,394.80	202,805.67	228,589.13	47.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,971.00	7,452.00	1,519.00	83.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	90,934.50	7,689.06	83,245.44	8.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	331,489.30	187,664.60	143,824.70	56.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,844,170.00	19,658,955.60	(814,785.60)	104.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,884,170.00	15,383,392.19	2,500,777.81	86.0
Улсын төсвөөс санхүүжих	17,884,170.00	15,383,392.19	2,500,777.81	86.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	960,000.00	4,275,563.41	(3,315,563.41)	445.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	960,000.00	4,275,563.41	(3,315,563.41)	445.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО	640	572	68	89.4
Төсвийн байгууллага	8	8	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	316	282	34	89.2
Удирдах ажилтан	1	1	0	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	184,436.99
УРСГАЛ ЗАРДАЛ	184,436.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,432.63
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,191.07
Нэмэгдэл	22,376.10
Урамшуулал	77,814.97
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,455.91
Тэтгэврийн даатгал	8,907.51
Тэтгэмжийн даатгал	1,222.15
ҮОМШӨ-ний даатгал	1,028.02
Ажилгүйдлийн даатгал	706.31
Эрүүл мэндийн даатгал	2,591.92
Эд хогшил, урсгал засварын зардал	11,000.00
Багаж, техник, хэрэгсэл	11,000.00
Урсгал засвар	23,086.05
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,086.05
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,699.60
Бараа үйлчилгээний бусад зардал	19,900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,799.60
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,000.00
Бусад урсгал шилжүүлэг	13,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	184,436.99
Нэмэлт санхүүжилтийн орлого	184,436.99
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,648.54
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	74,788.45

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гадаадын иргэн, харьяатын газар нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын хувьд холбогдох хууль, тогтоомжийн дагуу гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих, гадаадын иргэний виз, бүртгэлийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрхэм зорилготой.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан 9 үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Агентлагийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, агентлагийн удирдлага, зохион байгуулалтын нэгжүүдийн хамтын үйл ажиллагааг хангаж, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, олон нийтийг байгууллагын бодлого, үйл ажиллагааны мэдээллээр хангах, төрийн албанд манлайлал, салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах, шалган шийдвэрлэх эрх бүхий улсын ахлах болон улсын байцаагчдыг давтан болон мэргэшүүлэн сургах, чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, дотоод хяналт шалгалтыг хийх, аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчил, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үндсэн чиг үүргийн нэгжүүдээс ирүүлсэн дүн, тайлан мэдээг нягтлах, нэгтгэх;
2. Гадаадын иргэнийг бүртгэх, тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух, түр ирэгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад орогнох эрх олгох, дүгнэлт гаргах;
3. Иргэний харьяаллын асуудлаар гаргасан хүсэлтийг хянаж шийдвэрлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл олгох, Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах гадаадын иргэний хүсэлтийг хянах, дүгнэлт гаргах, шийдвэрлэх;
4. Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, холбогдох зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг шалган шийдвэрлэх;
5. Агентлагийн төсвийн төвлөрүүлэн болон орон нутаг дахь нэгжийн төсвийн шууд захирагчийн хөрөнгө оруулалтыг төсөвлөх, батлагдсан төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулах, тайлагнах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлыг зохион байгуулах, албан хаагчдад чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлэх;
6. Олон улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд, харилцан зорчих нөхцөлийн талаарх олон улсын болон хоёр талт гэрээний хэрэгжилтийг хангах;
7. Агентлагийн болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөлт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, салбарын статистик мэдээллийг нэгтгэн мэдээлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах;
8. Мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, үр дүнд хүргэх замаар цахим засаглал, инновацыг хэрэгжүүлэх;
9. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд ашиглаж буй цахим системүүд, тэдгээрийн хэрэглээ, төрийн үйлчилгээний бусад мэдээ, мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран гадаадын иргэн, түүнийг уригч иргэн, аж ахуйн нэгж байгууллага, харилцагчдад биечлэн болон холбогдох цахим систем бусад эх сурвалжийг ашиглан зөвлөгөө мэдээллийн үйлчилгээг үнэн зөв, шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус агентлаг нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын агентлагийн

эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна.

Агентлагийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус агентлаг нь Хяналт, шинжилгээ үнэлгээ, аудитын хэлтэстэй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан "Аргачлал батлах тухай", Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын журам", байгууллагын даргын 2021 оны А/233 дугаар тушаалаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам", 2024 оны А/454 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг мөрддөг байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2025 онд хийх дотоод аудитын төлөвлөгөөний дагуу санхүүгийн чиглэлээр 6, нийцлийн чиглэлээр 3, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 4, нийт 13 удаагийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, Хойд бүс дэх газарт "Ажлын хариуцлага сайжруулах тухай" 01 дугаар хугацаатай албан даалгавар, 7 зөвлөмж, Өмнөд бүс дэх газарт 2, Зүүн бүс дэх газарт 2, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст 3, Дорноговь аймаг дахь газарт 2, нийт 16 удаа зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 3 удаагийн зөвлөмжийг тус тус хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, стандарт, салбарын онцлогт нийцсэн боловч шинэчилж, нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 193.1 сая төгрөг болж, өмнөх оноос 125.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-		
Банканд байгаа бэлэн мөнгө	68.1	193.1	125.0
Төгрөг	68.1	193.1	125.0
Төрийн сангийн харилцах	48.4	28.6	-19.8
Арилжааны банк дахь харилцах	19.7	164.5	144.8
Гадаад валют	0	26.0	26.0
Арилжааны банк дахь харилцах	0	138.5	138.5
Дүн	68.1	193.1	125.0

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Төрийн сан дахь барьцаа хөрөнгийн 28.6 сая төгрөг, Голомт банканд дахь улсын тэмдэгтийн хураамжийн 164.5 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

- ГИХГ-ын Хойд бүс дэх газар: Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Э.Мөнхгэрэлд ээлжийн амралттай нь давхардуулан 0.4 сая төгрөгийн цалин тооцож олгосон;
- ГИХГ-ын Өмнөд бүс дэх газар: Тайлант онд албан хаагчдад сургалт зохион байгуулахдаа 10.3 сая төгрөгийг цай, хоол, буудлын төлбөрт зарцуулсан;
- ГИХГ болон Агаарын замын боомт хариуцсан газар: Татварын газрын аж ахуй нэгж, байгууллагын цахим тодорхойлолтоор улсын тэмдэгтийн хураамжийн 156.5 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

3.4.2 Авлага, урьдчилгаа

Авлагын дансны эцсийн үлдэгдэл 2,010.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,009.3 сая төгрөгөөр өссөн байна. Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 9.0 сая төгрөг болж, өмнөх оноос 31.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлага, урьдчилгаа данстын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
АВЛАГА	1.2	2,010.5	2,009.3
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.2	0.06	-1.14
Татаас, санхүүжилтийн авлага		2,010.4	2,010.4
УРЬДЧИЛГАА	40.1	9.0	-31.1
Урьдчилж гарсан зардал	40.1	9.0	-31.1
Дүн	41.3	2,019.5	1,978.2

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд ажиллагсадтай холбогдсон 1.2 сая төгрөгийн авлага байсныг 2025 оны нэгдүгээр улиралд барагдуулсан бөгөөд Сангийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Дансны үлдэгдэл буцаан олгох тухай" 47 дугаар тушаалаар ахмадын сангаас оны эцэст татан төвлөрүүлсэн 3.3 сая төгрөг, Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 240 дүгээр тушаалаар "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг шинэчлэн баталснаар Сангийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай" 24 дүгээр тушаалаар 2,007.1 сая төгрөгийг баталгаажуулсан тул авлагаар тус тус бүртгэсэн.

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурсан нь Төв болон Агаарын замын боомт хариуцсан газрын даатгалын зардал болон байрны түрээсийн зардлыг урьдчилж гарсан зардлаар тус тус

бүртгэсэн. Мөн Бүгд найрамдах Солонгос улс, Хөх хот дахь Дипломат төлөөлөгчийн газрын даатгал болон түрээсийн зардлыг урьдчилж гарсан зардлаар тус тус бүртгэсэн.

Дипломат төлөөлөгчийн газрын түрээс, даатгалын зардал болон агаарын замын боомт хариуцсан газрын тээврийн хэрэгслийн даатгал, дулааны зогсоолтой зардлыг аккруэл сууриар бүртгэснээс шалтгаалсан байна.

- ГИХГ (шууд): Ахмадын сангийн дансны үлдэгдэл 3.3 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос давж орсон 2,007.1 сая төгрөгийг сангийн яамнаас шууд татан төвлүүлснийг Сангийн сайдын 2026 оны 24, 2026 оны 47 дугаар тушаалаар буцаан олгох болсныг үндэслэн санхүүгийн тайланд авлагаар 2,010.4 сая төгрөгийг бүртгэсэн нь тайлант оны авлагыг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,228.7 сая төгрөг болж, өмнөх оноос 256.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	19.1	16.9	-2.2
Тусгай зориулалттай материал			
Эм боох материал	19.1	16.9	-2.2
Хангамжийн материал	1,466.3	1,211.7	-254.5
Бичиг хэргийн материал	40.6	27.8	-12.8
Аж ахуйн материал	193.1	181.6	-11.5
Сэлбэг хэрэгсэл	17.7	10.6	-7.1
Түлш, шатах тослох материал	69.3	59.9	-9.4
Барилгын засварын материал	6.5	8.9	2.4
Бусад хангамжийн материал	1,139.1	923.0	-216.1
Дүн	1,485.4	1,228.7	-256.7

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд худалдан авсан 967.6 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,276.4 сая төгрөг, нийт 2,243.9 сая төгрөгөөр бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд 1,696.4 сая төгрөгийн бараа материал зарцуулж, төв болон орон нутаг дахь газар хооронд шилжүүлсэн 730.9 сая төгрөг, бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 73.3 сая төгрөг, нийт 2,500.6 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Бараа материалын үлдэгдэл буурахад Монгол Улсад оршин суух гадаадын иргэдийн тоо нэмэгдсэнээр оршин суух үнэмлэхийн зарцуулалт 142.7 сая төгрөгөөр, Агаарын замын боомт хариуцсан газар, Дорноговь аймаг дахь газар, Хойд бүс дэх газар, Зүүн бүс дэх газрууд нь 73.4 сая төгрөгийн бараа материал акталсан тус тус нөлөөлжээ.

3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл тэг төгрөг болж, өмнөх оноос 2,737.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,737.1	0	-2,737.1
Дүн	2,737.1	0	-2,737.1

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023–2024 онд ГИХГ-ын Баруун бүс дэх газарт үйлчилгээний цогцолбор барилга баригдан ашиглалтад орсон бөгөөд уг барилгын санхүүжилт Төв байгууллагын дансаар дамжин “Бусад эргэлтийн хөрөнгө”-д бүртгэгдсэн байна. Төрийн

өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 265 дугаар тогтоолоор тус барилгыг ГИХГ-ын Баруун бүс дэх газарт балансаас балансад шилжүүлсэн.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 14,237.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4,359.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,595.3	11,721.7	3,126.4
Барилга, байгууламж, орон сууц	5,432.5	8,058.8	2,626.3
Авто-тээврийн хэрэгсэл	1,117.3	834.6	-282.7
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,512.4	2,310.8	798.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	464.2	455.1	-9.1
Зам, гүүрний байгууламж	50.3	44.7	-5.6
Бусад үндсэн хөрөнгө	18.6	17.7	-0.9
Биет бус хөрөнгө	1,283.1	2,515.8	1,232.7
Программ хангамж	716.7	1,935.5	1,218.8
Бусад биет бус хөрөнгө	566.4	580.3	13.9
Дүн	9,878.4	14,237.5	4,359.1

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 79.8 сая төгрөгийн, бараа материалаас шилжүүлэн бүртгэсэн 8.3 сая төгрөгийн, салбар дотроо шилжүүлсэн 3,202.8 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс шилжүүлсэн авсан 2,977.3 сая төгрөгийн, БНХАУ-ын хандив тусламжаар Дорноговь аймаг дахь газар 11.5 сая төгрөгийн, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн хугацааг сунгаж, үнийг шинэчилсэн 405,3 сая төгрөгийн, нийт 6,685.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө данснаас 405.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, дотооддоо 620.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, бусад байгууллага уруу 191.2 сая төгрөгийн шилжүүлсэн, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдлоор 740.9 сая төгрөг, нийт 1,957.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, эцсийн үлдэгдэл 18,121.1 сая төгрөг болсон байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 30.8 сая төгрөг болж, өмнөх оноос 7.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	23.5	30.8	7.3
Ажилчидтай холбогдсон өглөг	1.0	0.7	-0.3
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	22.5	28.3	5.8
Байгууллагад төлөх өглөг		1.1	1.1
Хувь хүмүүст төлөх өглөг		0.7	0.7
Урьдчилж орсон орлого	20.1	164.9	144.8
Дүн	43.6	195.7	152.1

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 28.3 сая төгрөг болж, өмнөх оноос 5.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгийн барьцаа авч үлдсэн холбоотой байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 17,483.2 сая төгрөг болж, өмнөх оноос 3,316.3 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,455.8	1,455.8	-
Хуримтлагдсан үр дүн	10,499.0	13,815.3	3,316.3
Өмнөх үеийн үр дүн	10,070.7	10,455.8	385.1
Тайлант үеийн үр дүн	428.4	3,316.5	2,888.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,211.9	2,211.9	-
Дүн	14,166.7	17,483.2	3,316.3

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант үеийн үр дүн: Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө болон туслах үйл ажиллагааны орлого нэмэгдсэн нь үр дүн өсөхөд нөлөөлсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус агентлагийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс урсгал зардлын 25,042.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 2,365.4 сая төгрөгийн санхүүжилтээр, туслах үйл ажиллагааны орлогоор 660.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлж, нийт зарлагыг 28,067.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс урсгал зардлыг 19,757.2 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 960.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, 20,757.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийг 1 удаа тодотгосон бөгөөд анхны баталсан төсвийг 1,913.0 сая төгрөгөөр хассан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 18,844.2 сая төгрөгийг баталсан бөгөөд улсын төсвийн санхүүжилтээр урсгал зардлын 17,844.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоор 960.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 16,343.4 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоор 4,275.4 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Тайлант онд Гадаадын иргэн, харьяатын газар нь оршин суух үнэмлэхийг дотооддоо хэвлэж борлуулсан, хилийн боомтуудын зорчих хөдөлгөөн болон зорчигчдын тоо нэмэгдэж, визийн үйлчилгээний орлого өссөнөөс шалтгаалан үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,315.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,343.4 сая төгрөг буюу 86.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,232.9 сая төгрөгөөр, холбооны суваг ашигласны төлбөрийг 13.0 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 145.3 сая төгрөгөөр, гадаадын иргэдийг албадан гаргах зардлыг 17.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70420	Цагаачлал, гадаад иргэдийн бүртгэл	18,844.2	16,343.4	2,500.8	87.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	17,554.9	15,321.9	2,233.0	87.3
80220	Холбооны суваг ашигласны хөлс	740.8	727.8	13.0	98.2

80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	431.4	202.8	228.6	47.0
81522	Гадаад иргэдийг албадан гаргах зардал	50.7	33.3	17.4	65.7
80918	Бусад	66.4	57.6	8.8	86.7
	Туслах үйл ажиллагааны орлого	960.0	4,275.6	-3,315.6	445.4

Улсын төсвийн санхүүжилтийн 1,537.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл, үндсэн үйл ажиллагааны орлогын 3,315.6 сая төгрөг, нийт 4,852.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. ГИХГ нь тайлант онд 11 орон тоогоор хэмнэн ажиллаж, цомхотгол хийгээгүй байна. Цалингийн зардалд 5,683.7 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 5,261.4 сая төгрөгийг зарцуулсан;
2. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны А/154 тушаалаар өдрийн 8 цагаар ажиллаж байгаа албан хаагч нарт хоолны хөнгөлөлт 34.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 1.0 мянган төгрөг олгохоор тогтоосон;
3. Гадаад томилолтын зардалд 37.0 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 31.3 сая төгрөгийг Даян дэлхийн аюулгүй байдлын олон улсын хамтын ажиллагааны форум, уулзалт, сургалт, цагаачлалын албаны мэдээллийн төв, гадаад иргэдийн төвд зөвлөгөө мэдээллийн үйлчилгээний үйл явц, хялбаршуулах арга зам, ашиглагдаж буй дэвшилтэт технологи, шинэлэг арга барилыг судлах уулзалт зэрэгт зарцуулсан;
4. Тайлант онд албан хаагчдын чадавхжуулах сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 6.9 сая төгрөг зарцуулсан;
5. Гадаадын иргэн, харьяатын газарт 6 нэр төрлийн 2,696.6 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байгаагаас 5 нь бүрэн ашиглагдаж, 1 одоогоор ашиглагдахгүй байна. Тайлант онд “E-Visa system” программын хөгжүүлэлтэд 28.9 сая төгрөгийг зарцуулсан;
6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, ямар нэгэн зардал гараагүй;
7. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн ЗДТГ-аас 109.6 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 74.8 сая төгрөг, нийт 184.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, урсгал зардалд 184.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 6 төрлийн 1,990.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд холбогдох эрх зүйн актын хүрээнд үнэлгээний хороо байгуулан tender.gov.mn цахим системд нээлттэй зарлаж, хуулийн дагуу шалгаруулалтыг зохион байгуулан, хэрэгжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем pimis.publicinvestment.gov.mn болон tender.gov.mn системд тухай бүр мэдээлж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд агентлаг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн агентлагийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, ажиллагсад олгох цалин, урамшууллын тооцооллыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл Санхүүгийн аудитын газрын аудитор С.Шийлэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гадаадын иргэн харьяатын газрын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/427 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 21,590.7 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, 215.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны 160 дугаар тогтоолоор “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ”-г тус тус баталсан байна. Төрийн тусгай албан хаагчийн цалингийн сүлжээгээр цалин хөлсийг тооцож, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон, 34 орон тоо дутуу ажилласнаар цалингийн санг нийт 1,114.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.6 Завсрын аудитын үр дүн

Завсрын аудитаар аудитын төлөвлөх үе шатны ажилбарыг хэрэгжүүлж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулсан.

4.7 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/1169 дүгээр албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна.

Биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 06/1709 дугаар албан бичгээр ирүүлснийг аудитын явцад хянаж, үнэлэхэд 1 зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100.0
Дүн	1	0	1	0	100.0

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн өмчийн эд хөрөнгө /сул чөлөөтэй зай талбай болох спорт заал, кофе шоп, цэцэрлэг/-ийг түрээслүүлсэн, улсын төсөвт төвлөрүүлэх нэмэлт орлогыг төвлөрүүлсэн асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 77.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 66.4 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлэн, 10.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмжийг өгсөн байна.

Өмнөх оноос төлбөрийн акт 0.9 сая төгрөгөөр, албан шаардлага 55.4 сая төгрөгөөр нэмэгдсэн бол зөвлөмж 20.5 сая төгрөгөөр буурсан байна.

Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Гадаадын иргэн, харьяатын газарт:

Илрүүлэлт 1. Барьцаа хөрөнгийн 100900012403 тоот дансанд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5.0 хувийн барьцааны хуулийн хугацаа дууссан 0.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”; 7 дугаар зүйлийн 7.7-т “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Барьцаа хөрөнгийн дансанд 2015 онд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5.0 хувийн барьцааны хуулийн хугацаа дууссан 0.3 сая төгрөгийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т өгөх 0.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагад төлөх өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2. Санхүүгийн тайлангийн татварын өр төлбөрийн үлдэгдлийг татварын тодорхойлолттой тулгахад Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар 1.7 сая төгрөг, Газрын төлбөр 0.08 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнаж, Татварын албатай тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан “Багаж, техник хэрэгсэл худалдан авах” тендерийн хэмнэлтээс 11.5 сая төгрөгийн 2 ширхэг компьютер худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтээс шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 4. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг чанаргүй хийж, тооллогын бүртгэл, илтгэх хуудас, нотлох баримтыг холбогдох журам, зааврын дагуу бэлтгээгүй байна. Үүнд:

- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан НХМаягт БМ-7 маягтын дагуу данс тус бүрээр ангилан тоолсон баримт бүрдүүлээгүй, үндсэн хөрөнгийг үлдэх өртгөөр нь тоолж, илтгэх хуудаст бичсэн;
- Санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлийг 668.6 сая төгрөг гэж тайлагнасан байхад тооллогын комиссын илтгэх хуудсанд 716.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 48.2 сая төгрөгийн зөрүүтэй тоолсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг чанаргүй хийж, тооллогын бүртгэл, илтгэх хуудас, нотлох баримтыг холбогдох журам, зааврын дагуу бэлтгээгүй зөрчлийг арилгаж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагчид:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байгаа ч тооллогын комиссын хийсэн тооллогод хяналт хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгө болон бараа материал хариуцсан нягтлан бодогч нь комиссын хийсэн тооллогын тооцоог бодож, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй, дотоод хяналт сул байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар баталсан НХМаягт БМ-7 маягт “Тооллогын дараа эд хариуцагч нарын тооцоог бодож илүүдлийг орлого болгох ба дутагдлыг төлүүлэх, эсвэл зарлага болгож шийдвэрлэнэ. Эд хариуцагчийн тооцоо бодсон баримтыг холбогдох нягтлан бодогч 2 хувь нөхөн бичиж тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Баримтын нэг хувь нягтлан бодогчид, үлдэх хувь эд хариуцагчид хадгалагдана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хагас бүтэн жилийн тооллогын комисс нь сангийн сайдын 2017 оны 347 дугаар маягтаар тооллогыг чанартай хийж гүйцэтгэх, тооллогын дараа эд хариуцагч нарын тооцоог бодож илүүдлийг орлого болгох ба дутагдлыг төлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган ҮАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
ГИХГ /ТТЗ/	1							1			
ГИХГ /аппарат/	5	62,335.0	1	349.0	4	61,986.0					
ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	2	3,782.0			1	3,782.0	1				
ГИХГ-ын Өмнөд бүс дэх газар	1	10,320.0					1	10,320.0			
ГИХГ-ын Хойд бүс дэх газар	1	428.7	1	428.7							
ГИХГ-ын Зүүн бүс дэх газар	1	750.0			1	750.0					
Дорноговь аймаг дахь ГИХГ	1	175.0	1	175.0							
Нийт дүн	13	77,790.7	3	952.7	6	66,518.0	3	10,320.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 199/A1560348

Улаанбаатар хот

САГ-2026/62/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барьцаа хөрөнгийн 100900012403 тоот дансанд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5.0 хувийн барьцааны хуулийн хугацаа дууссан 349,000.00 /Гурван зуун дөчин есөн мянган төгрөг/-ийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"; 7 дугаар зүйлийн 7.7-т "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Барьцаа хөрөнгийн дансанд 2015 онд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5.0 хувийн барьцааны хуулийн хугацаа дууссан 349,000.00 /Гурван зуун дөчин есөн мянган төгрөг/-ийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын дарга (Н.Ууганбаяр), Ерөнхий нягтлан бодогч (Ж.Солонго) нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9976109
ATA16087
9075081411

Z_Akt_2026_0325_SAG-1.Docx

1526200256



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 10301/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/62/КА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т өгөх 505,000.00 /Таван зуун таван мянган төгрөг/-ийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч байгууллагад төлөх өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын дарга (Н.Ууганбаяр), Ерөнхий нягтлан бодогч (Ж.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1031/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/62/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоож тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан “Багаж, техник хэрэгсэл худалдан авах” тендерийн хэмнэлтээс 11,498,000.00 /Арван нэгэн сая дөрвөн зуун ерэн найман мянган төгрөг/-ийн 2 ширхэг компьютер худалдан авсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтээс шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын дарга (Н.Ууганбаяр), Ерөнхий нягтлан бодогч (Ж.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1032/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/62/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн татварын өр төлбөрийн үлдэгдлийг татварын тодорхойлолттой тулгахад Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар 1,719,685.00 /Нэг сая долоон зуун арван есөн мянга зургаан зуун наян таван төгрөг/, Газрын төлбөр 76,164.00 /Далан зургаан мянга нэг зуун жаран дөрвөн төгрөг/-өөр зөрүүтэй тайлагнаж, Татварын албатай тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын дарга (Н.Ууганбаяр), Ерөнхий нягтлан бодогч (Ж.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1033/А1560348

Улаанбаатар хот

САГ - 2026/62/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ.

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг чанаргүй хийж, тооллогын бүртгэл, илтгэх хуудас, нотлох баримтыг холбогдох журам, зааврын дагуу бэлтгээгүй байна. Үүнд:

- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан НХМаягт БМ-7 маягтын дагуу данс тус бүрээр ангилан тоолсон баримт бүрдүүлээгүй, үндсэн хөрөнгийг үлдэх өртгөөр нь тоолж, илтгэх хуудаст бичсэн;
- Санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлийг 668,615,398.47 /Зургаан зуун жаран найман сая зургаан зуун арван таван мянга гурван зуун ерэн найман төгрөг дөчин долоон мөнгө/ гэж тайлагнасан байхад тооллогын комиссын илтгэх хуудсанд 716,802,580.61 /Долоон зуун арван зургаан сая найман зуун хоёр мянга таван зуун наян төгрөг жаран нэгэн мөнгө/-ний үлдэгдэлтэй буюу 48,187,182.14 /Дөчин найман сая нэг зуун наян долоон мянга нэг зуун наян хоёр төгрөг арван дөрвөн мөнгө/-ний зөрүүтэй тоолсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг чанаргүй хийж, тооллогын бүртгэл, илтгэх хуудас, нотлох баримтыг холбогдох журам, зааврын дагуу бэлтгээгүй зөрчлийг арилгаж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын дарга (Н.Ууганбаяр), Ерөнхий нягтлан бодогч (Ж.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА